



# ТӨВ ЧАНДМАНЬ ДЭХГ /ОНӨААТҮГ/-ЫН 2014 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

## Аудитын тайлан

Төв аймгийн аудитын газрын дарга,  
Тэргүүлэх аудитор Л.Жаргалсайхан  
Утас: 70272582  
И-мэйл: jargalsaihan\_tuv@yahoo.com  
Факс: 01-272-22582

Аудитын менежер: О.Амаржаргал  
Утас: 70273465  
И-мэйл: amaraa\_tuv@yahoo.com

Аудитор: Ц.Саранчимэг  
Утас: 70273204  
И-мэйл: tsaranchimeg@yahoo.com

Хавсралт 1: Агуулга  
Хавсралт 2: Аудитын гэрчилгээ  
Хавсралт 3: Менежментийн захидал  
Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан  
Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аймгийн Аудитын газрын хаяг:  
Төв аймаг Зуунмод сум 1-р баг  
Төрийн байгууллагуудын ордон  
Цахим хуудас: tuv@audit.gov.mn

2015 оны 04 дугаар сар

## АГУУЛГА

---

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
8. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
9. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
10. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
11. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
12. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
13. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
14. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
15. Зөвлөмж
16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

### **Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:**

Төсвийн тухай хуулийн 8.9.8, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дүгээр зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төв Чандмань ДЭХГ /ОНӨААТҮГ/-ын төсвийн 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Төв Чандмань ДЭХГ /ОНӨААТҮГ/-ын 2014 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон СТОУС болон НББОУС-стандарт, түүнд нийцүүлэн гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Орон нутгийн өмчит үйлвэрийн газрын удирдлага санхүүгийн тайлангаа НББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, программ хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Төв Чандмань ДЭХГ /ОНӨААТҮГ/-ын 2014 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2015 оны 02 дүгээр сарын 15-наас 2015 оны 03 дүгээр сарын 15-ныг хүртэл хийхээр төлөвлөн Төв аймгийн Аудитын газрын санхүүгийн аудитын багийн гишүүн аудитор Ц.Саранчимэг хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Төв Чандмань ДЭХГ /ОНӨААТҮГ/-ын 2014 оны төсвийн санхүүгийн тайланг 2015 оны 02 дугаар сарын 15-нд Төв аймгийн Аудитын газарт ирүүлсэн байна.

Төв аймгийн Аудитын газар аудитыг 2015 оны 2 дүгээр сарын 15-наас 2015 оны 3 дугаар сарын 15-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2015 оны 4 дүгээр сарын 10-нд Төв Чандмань ДЭХГ /ОНӨААТҮГ/-ын удирдлагад гардуулна.

### **Байгууллагын хууль, эрх зүйн орчин:**

Төв Чандмань ДЭХ ОНӨҮГ-азар нь Эрчим хүчний тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлийн тухай хууль, Барилгын тухай хууль, Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм, Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, ТБОНӨХБАҮХАТХуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой хуулинд өөрчлөлт ороогүй байна.

### **Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:**

Эрчим хүчний тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1-д эрчим хүчний нөөцийг ашиглан эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, диспетчерийн зохицуулалт хийх, хангах үйл ажиллагаа эрхлэх, эрчим хүчний барилга байгууламж барих болон эрчим хүчийг хэрэглэхтэй холбогдон үүссэн харилцааг зохицуулахад оршино, 3.1.1-д “эрчим хүч” гэж эрчим хүчний нөөц, түүнийг ашиглан хэрэглэгчийн хэрэгцээнд зориулан үйлдвэрлэсэн цахилгаан, дулааныг гэж, 17.1-д Эрчим хүчээр зохицуулалттай хангах тусгай зөвшөөрлөөр хуулийн этгээдэд цахилгаан, дулаан үйлдвэрлэх, дамжуулах, түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигчээс цахилгаан, дулаан худалдан авах, цахилгаан импортлох, цахилгаан, дулааныг хэрэглэгчид худалдах эрхийг олгоно гэж заасан байна.

Төв Чандмань ДЭХ ОНӨҮГазар нь хэрэглэгчийн ая тухтай ажиллаж амьдрах нөхцлийг бүрдүүлэхийн төлөө ус, дулаан, ариутгах татуургаар үйлчилнэ гэж байгууллагын үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн Орон нутгийн өмчийн талаархи Засаг даргын бүрэн эрхийн 1-д ИТХ-аас олгосон эрх хэмжээний дотор орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулна, Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1.39 –д “Төрийн чиг үүрэгт хамаарах ажил үйлчилгээг гүйцэтгэгч” гэж төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг гэрээний дагуу гүйцэтгэж, тухайн ажил, үйлчилгээний чанар, тоо хэмжээ, хүрэх үр дүнгийн талаарх хариуцлагыг бие даан хүлээх этгээд гэж тодорхойлсны дагуу Аймгийн засаг даргатай гэрээ байгуулан ТУЗ-ийн баталсан төлөвлөгөөний дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий үүргийг Төв Чандмань ДЭХГ /ОНӨААТҮГ/-ын захирал гүйцэтгэж байна.

Төв Чандмань ДЭХГ /ОНӨААТҮГ/-ын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

**Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:**

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд,НББОУС, СТОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Төв Чандмань ДЭХГ /ОНӨААТҮГ/-ын төсвийн 2014 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар 33 аудитын хяналтын горим, нарийвчилсан сорилыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан мөрдөж ажиллаж байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь НББОУС-тай нийцсэн байна. ОУ-ын стандарттай нийцсэн бүртгэлийн бодлоготой, бүртгэлийн програм уялдсан байна. Гэвч заримт нэг алдаа байгааг тухай бүрд нягтлан бодогчид танилцуулсан болно.

Ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн программаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

**Дотоод хяналт:**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, түүнийг хэрэгжүүлэхээр гаргасан заавар, журмыг хэрэгжүүлж, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагааг бүртгэлийн програмаар боловсруулж байна. Эдгээр журам нь НББОУС-тай нийцсэн байна.

**Үйл ажиллагааны орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:**

ТУЗ-ийн 2014 оны 2 дугаар сарын 06-ны өдрийн дугаар 03 тоот тогтоолоор үндсэн үйл ажиллагааны орлогыг 4197111.3 мянган төгрөг, үндсэн бус үйл ажиллагааны орлогыг 8600.0 мянган төгрөгөөр, үндсэн үйл ажиллагааны зардлыг 4422835.2 мянган төгрөг, үндсэн бус үйл ажиллагааны зарлагыг 7200.0 мянган төгрөгөөр тус тус баталсан байна.

Төв Чандмань ДЭХ ОНӨГазар нь 2014 онд гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны орлого 4440091.9 мянган төгрөг, үндсэн бус үйл ажиллагааны орлогыг 644815.5 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны зардал 4329157.4 мянган төгрөг, үндсэн бус үйл ажиллагааны зардал 661009.0 мянган төгрөгөөр тайлагнагдсан байна.

Батлагдсан төлөвлөгөөтэй харьцуулбал үндсэн үйл ажиллагааны орлого 242980.6 мянган төгрөг, үндсэн бус үйл ажиллагааны орлогыг 636215.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Мөн зардлыг төлөвлөгөөтэй харьцуулбал үндсэн үйл ажиллагааны зардал 93678.4 мянган төгрөгөөр буурч, үндсэн бус үйл ажиллагааны зардал 653809.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Эндээс харахад үйл ажиллагааны орлого өссөн шалтгаан нь дулаан борлуулах нэгж талбай үнэ нэмэгдсэн, шинээр орон сууц баригдсантай холбоотой талбай нэмэгдсэн, 2014 онд Бүрэн сумаас дулааны борлуулт нэмэгдэж орсон, өмнөх онд төсвийн байгууллагуудын шийдвэрлэгдээгүй авлагыг хойшлуулагдсан борлуулалтаар бүртгэсэн байсан орлого орсон зэрэг нь нөлөөлсөн байна. Үйл ажиллагааны бус орлого өссөн нь тусгай зөвшөөрлийн дагуу хийгдсэн 528507.5 мянган төгрөгийн барилга сантехникийн угсарлтын ажилтай орлоготой холбоотой бөгөөд энэ нь үйл ажиллагааны бус тусгай зөвшөөрөл авч эрх үүссэн тус байгууллагын туслах үйл ажиллагаа юм.

Зардлын хувьд үндсэн үйл ажиллагааны зардал буурсан нь цалин шимтгэл 70630.5 мянган төгрөг, шатах тослох материал 9375.0 мянган төгрөг, хөдөлмөр хамгаалалын зардал 9859.8 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна. Үйл ажиллагааны зардал 653809.0 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зөвшөөрөлтэй хийсэн ажлын гүйцэтгэлтэй холбоотой өссөн ба үүнийг ТУЗ-өөр оруулан зарцуулах эрхийг баталгаажуулаагүй захиран зарцуулсан байна.

**Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:**

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр хяналтын 7, нарийвчилсан, нийт 33 горим, сорил гүйцэтгэв.

Үр дагавар Эдгээр эрсдэлүүд нь ТУЗ-ийн шийдвэргүйгээр зарцуулсан, тусгай зөвшөөрөлтэй туслах үйл ажиллагааг үндсэн бус үйл ажиллагааны орлогоор тайлагнасан, татварын тооцоог байгууллага хоорондын дулааны авлагаар хаадаг зэрэг нь байгууллагын үйл ажиллагааны цар хүрээг бууруулсан, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхгүй зөрчдөг зэрэг муу үр дагаварт хүрч болзошгүй байна.

**Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар:**

Төв Чандмань ДЭХГ /ОНӨААТҮГ/-ын 2014 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн

тайланд нөлөөлөхүйц хэмжээний 2000.0 мянган төгрөгөөс дээш дүнтэй ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/ Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт зардлын 76.0 хувийг эзэлж байна.

**Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг  
шийдвэрлэсэн талаар:**

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний 73536.1 мянган төгрөгийн алдаа илэрсэн байна. Үүнд:

1. Бүрэн сумын дулааны зуухны шинэчлэлтийн барилга угсралтын ажил 649656.5 мянган төгрөгөөр хийгдэх ажил нь 2014 онд гэрээгүй хийгдэж зуухны шинэчлэл, барилга угсралтын ажил нь дуусч Бүрэн сумын төсөвт байгууллагуудыг дулаанаар хангаж 34163.1 мянган төгрөгийн борлуулалтын орлого олсон байна. Энэ нь улсын комисс хүлээж аваагүй байхад ашиг орлого олох үйл ажиллагааг явуулж Барилгын тухай хуулийн 12.1.Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх... тэй холбогдсон ажиллагааг гэрээгүйгээр гүйцэтгэхийг хориглоно, 19.2.Барьж дуусаагүй, дууссан боловч ашиглалтад хүлээж аваагүй барилга байгууламжийг ашиглахыг хориглоно гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: улсын комисс хүлээж аваагүй байхад Барилгын тухай хуулийн 15.5-д Ашиглалтад хүлээлгэж өгөөгүй барилга байгууламжийг барилгын ажлын явцад шаардагдах цахилгаан, дулаан, халуун, хүйтэн усаар түр хангах бөгөөд байнгын ашиглалтад хүлээн аваагүй барилга байгууламжийг цахилгаан, холбоо, дулаан, халуун, хүйтэн усаар хангахыг хориглоно гэснийг зөрчин үйл ажиллагаа явуулж 34163.1 мянган төгрөгийн орлогыг төсөвт татахаар төлбөрийн акт бичлээ.

2. Татвар хэлтсийн дулаан цэвэр усны үнэ 32311.8 мянган төгрөгийн авлагыг НӨАТатварт хоорондын тооцоогоор хааж Татварын ерөнхий хуулийн 18 дугаар зүйлд татвар төлөгчийн үүргийн 18.1.1-д татвар ногдох зүйл, татвараа үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн: Татварын төлөгчийн үүргээ биелүүлэн дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх талаар зөвлөмж хүргүүлэв.

3. Үүрэг трейд ХХК нь Төв аймгийн Зуунмод сумын төвд Биен тамир спорт цогцолборын барилгыг 2011 онд ашиглалтанд өгөх үед дулааны төлбөр 30.0 сая төгрөгийн авлага үүссэний 15.0 сая төгрөгийг тухайнд онд нь барагдуулж үлдэгдэл 15.0 сая төгрөгийг 2012 онд барагдуулах тохиролцсон гэх боловч 2012 онд 5.0 сая төгрөг, 2013 онд 5.0 сая, 2014 онд 5.0 сая төгрөг барагдуулсан энэхүү авлагыг данс бүртгэлд тусгаагүй байсан байна.

Шийдвэрлэсэн: Шинээр барилга баригдаж буй газруудад Барилгын тухай хуулийн 15.5-д Ашиглалтад хүлээлгэж өгөөгүй барилга байгууламжийг барилгын ажлын явцад шаардагдах... дулаан, халуун, хүйтэн усаар түр хангах гэснийг үндэслэн хийгдэж байгааг ажлын гэрээг үндэслэн авлагын тайланд тусгаж байх талаар зөвлөмж өглөө.

4. Дулаан цэвэр бохир усны борлуулалтын авлагыг хоорондын тооцоогоор хаасныг түүвэрчлэн шалгахад Зуунмод гол ХХК /Чансаа

зоогийн газар/ 387.7 мянган төгрөг, Цогт-Өлзийт ХХК 247.7 мянган төгрөгийн хоолны зардалд эрх зүйн актгүйгээр шийдвэргүйгээр хаасан байна.

Шийдвэрлэсэн: Шийдвэргүйгээр зарцуулж хоорондын тооцоогоор хаасан хоолны зардал болох 635.4 мянган төгрөгийг төлүүлэхээр төлбөрийн акт бичлээ.

5. ТУЗ-ийн шийдвэргүй гүйцэтгэх захирал өөртөө үр дүнгийн шагнал 1425.9 мянган төгрөгийг авсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 19 дүгээр зүйлд Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захиралтай байгуулах гэрээний 8-д цалин, нэмэгдэл хөлс, энэ хуульд заасан урамшуулалын нөхцөлийг заасан байна. Иймд гэрээг дүгнүүлж урамшуулал аваагүй байгаа нь энэхүү хуулийн заалт зөрчигдсөн байна.

Шийдвэрлэсэн: Шийдвэргүй авсан урамшуулалын 1425.9 мянган төгрөгийг төлүүлэхээр төлбөрийн акт бичлээ.

Материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

6. Санхүү, эдийн засгийн сайдын 2000 оны 116 тоот тушаалын хавсралтаар батлагдсан "Аж ахуйн нэгж, байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны үлгэрчилсэн заавар"-ын 11.1-д Бусад орлого ба олз гэдэг нь аж ахуйн нэгж, байгууллагын байнгын бус буюу гэнэтийн ажил гүйлгээнээс түүнчлэн эздийн орлого буюу хөрөнгө оруулалтаас бусад тухайн тайлант хугацаанд уг аж ахуйн нэгж, байгууллагад нөлөөлөх бүх ажил гүйлгээ, үйл явдал нөхцөл байдлын үр дүнд өмчид (цэвэр хөрөнгөнд) гарсан өсөлт гэж тодорхойлсон тус байгууллага нь тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааны орлогыг үндсэн бус үйл ажиллагааны орлогоор бүртгэсэн ба үүнтэй холбоотой орлого зарлагыг ТУЗ-ийн шийдвэргүйгээр зарцуулсан байна.

Шийдвэрлэсэн: Цаашид тусгай зөвшөөрөлтэй хийгдэж буй ажлууд болон бусад /үүнд цайны газар, бохир зөөх зэрэг/ гэрээгээр гүйцэтгэж байгаа бүхийл ажлын орлого, зарлагыг ТУЗ-өөр батлуулан зарцуулж байх зөвлөмжийг өглөө.

7. 124047.1 мянган төгрөгийн хөрөнгө нь хангамжийн материалын дансанд бүртгэлтэй байгаа нь Сангийн сайдын 2012 оны 77 тоот тушаалаар батлагдсан Аж ахуйн нэгжийн Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх зааварын 2 бүлгийн санхүүгийн тайлан бэлтгэх зааварт Үндсэн хөрөнгийг шинж чанар, үйл ажиллагаанд ашиглагдах байдлаар нь ангилна, үндсэн хөрөнгийн 5-д Тавилга, эд хогшилд нэг жилээс дээш хугацаанд ашиглагдах тавилга, аж ахуйн эд хогшил, багаж хэрэгслүүд хамаарна гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: 124047.1 мянган төгрөгийн хөрөнгийг хангамжийн материалын данснаас үндсэн хөрөнгийн бүртгэлд шилжүүлэн бүртгэх албан шаардлага өглөө.

8. 234846.9 мянган төгрөгийн дуусаагүй барилга тооллогын бүртгэлд тооллогдоогүй орхигдуулсан байна. Энэ нь ТБОНӨТХуулийн 72 зүйлийн Тооллогын комиссын эрх үүрэгийн 4-д комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх гэснийг хэрэгжүүлэлгүй дутуу бүртгэл хийж өгсөн байна.

Шийдвэрлэсэн: ТБОНӨТХуулийн 72 зүйлд заасан тооллогын комиссын эрх үүрэгийн хэрэгжилтийг тооцож үр дүнг хэлэлцэж байх талаар зөвлөмж өглөө.

9. Нэхэмжлэхгүй, цалин, шагналын гарын үсэггүй зэрэг 37082.5 мянган анхан шатны баримтыг бүрдэл дутуу ажил гүйлгээг бүртгэл тайланд тусгаж Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7.7. Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгахыг хориглоно гэснийг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн:НББТХуулийн 7.7 –д заасан заалтыг мөрдөж анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг тайланд бүртгэж тусгахгүй байх талаар шат шатны хяналтыг хэрэгжүүлж ажиллах

10. Ажилчдын цалингаас гар утасны суутгалыг суутгасан нь Хөдөлмөрийн тухай хуулийн 63 дугаар зүйлд цалин хөлснөөс хийх суутгал, түүний хэмжээг хязгаарлах тухай, 63.1.1-д ажилтны нэг сарын дундаж цалин хөлснөөс хэтрэхгүй хэмжээний хохирлыг нөхөн төлүүлэх тухай ажил олгогчийн шийдвэр гарсан, 63.1.2-д хууль тогтоомжид заасан бусад тохиолдолд суутгал хийж болно гэж заасныг зөрчин хувийн хэрэглээний зардал 32030.1 мянган төгрөгийг суутгасан байна.

Шийдвэрлэсэн:Хөдөлмөрийн тухай хуулийн 63.1 дэх заалтыг мөрдөж ажлын онцлогоос шалтгаалан зайлшгүй хийх шаардлагатай бол хамт олны хурлаар оруулан хэлэлцүүлж, гэрээ байгуулах талаар зөвлөмж өглөө.

### **Материаллаг бүс залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:**

Аудитын явцад залруулах материаллаг алдаа тогтоогдоогүй болно. ТУЗ-ийн шийдвэргүйгээр зарцуулсан, хангамжийн материалд бүртгэлтэй байсан үндсэн хөрөнгө, тооллогын бүртгэлд дутуу бүртгэгдсэн хөрөнгө, анхан шатны баримын бүрдэл дутуугаар хийгдсэн гүйлгээ, ажилчдын хувийн хэрэглээний зардлыг суутгасан зэрэг материаллаг бүс алдаанууд залруулагдаагүй болно.

### **Анхаарал татахуйц бусад чухал асуудал:**

Тусгай зөвшөөрөлтэй хийгдэж буй ажлуудын зардлыг ТУЗ-өөр батлуулан зарцуулдаггүйгээс ажлын төсөвт байхгүй ихээхэн дүнтэй шагнал урамшуулал олгогдож байна.

### **Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:**

Тухайн аудитын хамрах хүрээний асуудал боловч аудитын хугацааны шалтгаанаас аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй байж болох тусгай зөвшөөрөлөөр гүйцэтгэж буй ажлуудыг завсрын аудитаар нөхөн шалгахаар тогтоов.

### **Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:**

Төв Чандмань ДЭХГ /ОНӨААТҮГ/-ын төсвийн 2014 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 1115847.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс 955575.9 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч, 124047.1 мянган төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, 36224.3 мянган төгрөгийн төлбөрийн акт бичлээ.

**Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:**

Төв Чандмань ДЭХГ /ОНӨААТҮГ/-ын төсвийн 2013 оны санхүүгийн тайланд Төв аймгийн Аудитын газраас хийсэн аудитаар зөвлөмж өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

**Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт:**  
**Зөрчилгүй санал дүгнэлт**

Төв Чандмань ДЭХГ /ОНӨААТҮГ/-ын төсвийн 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 8 хуудас, байгууллагын санал 1 хуудсыг тус тус хавсаргав.

**АУДИТЫН ТАЙЛАНГ**

**ХЯНАСАН:**

**ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР**

**Л.ЖАРГАЛСАЙХАН  
О.АМАРЖАРГАЛ**

**БЭЛТГЭСЭН:**

**АУДИТОР**

**Ц.САРАНЧИМЭГ**

**Огноо: 2015.04.10**